

Эдийн засаг, хөгжлийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны
01 дүгээр сарын 13-ний өдрийн 04 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Гэрээний дугаар:	2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Эдийн засаг, хөгжлийн яам
3. Орон тоо, албан тушаал: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Санхүүгийн ажилтан	
4. Ажлын байрны шууд харьяалах удирдах албан тушаалын нэр: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч	

Б. ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны үндсэн зорилго:	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, журам заавар, хөгжлийн түншүүдийн журмын дагуу зохион байгуулж төслийн санхүүжилтийг зохицуулах, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч байгууллагууд, хөгжлийн түншүүд болон бусад холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй уялдаа холбоотой ажиллах. Санхүүжилт олгох, төсөв, нягтлан бодох бүртгэл хөтлөх, хэрэгжилтийг хангах, аудитууудын илрүүлсэн зөрчлийг шуурхай арилгах, Төслийн нэгдсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, мөн хяналт тавих, тайлагнах шаардлагыг хангахад нь туслах. Сангийн яам болон бусад хөгжлийн түншүүдийн аудитаар баталгаажсан төслийн санхүүгийн тайланг цаг тухайд нь өгөхөд нь тусалцаа үзүүлэх. Дотоод хяналт, баталгаажуулалт, хөрөнгийн урсгал, гүйцэтгэл болон тайлагналтыг бий болгох/бэхжүүлэх.
2. Ажлын байрны зорилтууд:	1. Төслийн хөрөнгийг Засгийн газар, хөгжлийн түншүүдийн бодлого, дүрэм, журмын дагуу төслийн үндсэн зардлуудад хуваарилагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах ажлыг хийж гүйцэтгэх; Хэрэгжүүлэгч байгууллагуудад зориулсан санхүүгийн удирдлагын тогтолцоог бий болгох/бэхжүүлэх. Хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч байгууллагууд, хөгжлийн түншүүдэд бүх мэдээллийг бүртгэх, тухайн мэдээллийг тайлагнах сайн тогтолцоог бий болгож /бэхжүүлэх, хөрөнгийн урсгалыг хянах механизмыг бий болгох/бэхжүүлэх. 2. Төслийн санхүүгийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн мэдээ, тайланг бэлтгэх, тайлагнах, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид Төслийн нэгдсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд нь тусалцаа үзүүлэх, мөн хяналт тавих, тайлагнах шаардлагыг хангахад нь туслах зэргээр зээл авахад нь дэмжлэг үзүүлэх. Сангийн яам, хөгжлийн түншүүдэд аудитаар баталгаажсан төслийн

	санхүүгийн тайланг цаг тухайд нь өгөхөд нь туслалцаа үзүүлэх. 3. Санхүүгийн тайланд хөгжлийн түншүүдийн шаардлага хангахуйц бие даасан хараат бус аудитын байгууллагаар аудит хийлгүүлэх Дотоод хяналт, баталгаажуулалт, хөрөнгийн урсгал, гүйцэтгэл болон тайлагналтыг бий болгох/бэхжүүлэх. 4. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн Хөгжлийн түнш байгууллагуудын дүрэм, журмын шаардлагад нийцүүлэн тайлагнал хийх, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн нэгдсэн тайланг нэгтгэн гаргах. 5. ЭЗХЯ-д хэрэгжиж буй бүх төслийн үйл ажиллагааны зохицуулалт, нэгдсэн төлөвлөгөө, хэрэгжилт, тайлагналыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн түвшинд бүрэн хангах; 6. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн цар хүрээнд багтах нийт төслийн санхүү, худалдан авалт, тайлан мэдээ, хэрэгжилтийн уялдааг хангах; 7. Шинээр эхлэх төслүүдийн үйл ажиллагааг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, зохион байгуулалттай уялдуулан хэрэгжүүлэх бодлогын хүрээг баримтлах;		
3.Ажлын байрны үндсэн үйл ажиллагаа:	Хугацаа, хуваарь	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
1. Төслийн үйл ажиллагаатай холбоотой бүх зардлуудыг санхүүгийн стандарт, шаардлагын дагуу бүртгэж, нотлох баримтуудаар баталгаажуулна. Зөрчлийг Төслийн зохицуулагчид тайлагнаж, гарсан алдаа зөрчлийг засаж залруулах;	Өдөр бүр	Төслийн үйл ажиллагаатай холбоотой бүх зардлуудыг холбогдох стандарт, хууль, журмын дагуу бүртгэж, хүчин төгөлдөр нотлох баримтаар баталгаажуулсан байна.	
2. Төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр тус бүрээр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааг санхүүжүүлэх урсгал зардлын дэд данс, үндсэн үйл ажиллагаанд хамаарах хөрөнгө оруулалт, зөвлөх, сургалт болон бусад зардлыг санхүүжүүлэх дэд	Тухай бүр	Төслийн харилцах дансыг нээсэн байна.	

дансыг нээж, холбогдох журмын дагуу зохион байгуулах; 3. Зарцуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага буюу ЭЗХЯ, үндэсний НББ-ийн стандарт болон Хөгжлийн түншүүдийн Зээл, тусламжийн гэрээ болон төслийн гарын авлагын дагуу хэрэгжүүлнэ; 4. Хөгжлийн түншүүдийн журмын дагуу зарцуулалтын үйл ажиллагааг цаг тухайд нь тайлагнах, харилцагч болон зөвлөхүүдийн төлбөрийн нэхэмжлэхийг хянаж, холбогдох байгууллагуудаар хянан баталгаажуулж, гүйцэтгэнэ; 5. Зээл, тусламжийн хөрөнгийн үр дүнтэй удирдлага, хяналтыг хангах нягтлан бодох бүртгэлийн аргыг бэлтгэх, хэрэгжүүлэх; 6. Төслийн санхүүгийн удирдлагын гарын авлагыг боловсруулах, төслийн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх; 7. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн Хөгжлийн түнш байгууллагуудын дүрэм, журмын шаардлагад нийцүүлэн тайлагнал хийх, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн нэгдсэн тайланг нэгтгэн гаргах.	Өдөр бүр Тухай бүр ХАА-ны төлөвлөгөөнд заасан хугацаанд ХАА-ны төлөвлөгөөнд заасан хугацаанд	Төслийн зээл, тусламжийн хөрөнгийг холбогдох стандарт, гэрээ, журмын дагуу зарцуулсан байна. Төлбөрийг цаг тухайд нь хийсэн байна. Зээл, тусламжийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулсан байна. Төслийн санхүүгийн удирдлагын гарын авлага боловсруулагдсан байна.
8. Төслийн зээлийн хөрөнгийг урсгал зардал болон хөрөнгийн зардал хэмээн ангилж, тооцоо хийн, дараа оны төсөвт тусгуулах саналаа төсөл хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлэх; 9. Төслийн санхүүгийн тайланг зээлдүүлэгчийн болон Сангийн яамны холбогдох журам, зааварт нийцүүлэх валют болон төгрөгөөр тус тус бэлтгэх, ТЕЗ-	III улирал 2 дугаар сарын 10, 7 дугаар сарын 25-ны дотор	Төслийн 2024 оны төсвийн төсөл, 2024 оны төсвийн төсөөллийг бэлтгэн хуулийн хугацаанд ЭЗХЯ, Сангийн яаманд хүргүүлсэн байна. Төслийн санхүүгийн тайланг хагас жил, бүтэн жилээр бэлтгэн хуулийн хугацаанд ТЕЗ,

ын санхүүгийн тайланд нэгтгүүлэх; 10. Төслийн үйл ажиллагааны зардлын төсвийг бэлтгэж, зарцуулалт, гүйцэтгэлийг хянах, хянуулж, төслийн санхүүгийн хэрэгжилт, зарцуулалтын тайланг улирал тутам гаргаж, улирлын төслийн тайланд хавсаргах 11. Төслийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллын дагуу төслийн зарцуулалтын тайлан мэдээнд холбогдох маягтын дагуу бэлтгэн ТЭЗ-д хүргүүлэх; 12. НӨАТ-аас чөлөөлөгдсөн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын тайланг бэлтгэж, илгээх, холбогдох баримтуудын хамт Татварын ерөнхий газарт хүргүүлэх; 13. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын НДШ, ХХОАТ-ыг тооцож, харьяалагдах албаны дансанд шилжүүлэх, тайлагнах; 14. Төслийн үйл ажиллагаа, санхүү бүртгэл, төсвийн гүйцэтгэл болон дансны мэдээллийг тогтсон хугацаанд Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлагнах; 15. Төслийн ерөнхий болон дэлгэрэнгүй мэдээлэл, төслийн хэрэгжилтэд хамаарах тайлан мэдээг журамд заасан хугацаанд Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний нэгдсэн санд оруулах, шинэчлэх; 16. ЭЗХЯ, СЯ болон Хөгжлийн түншүүдээс шаардсан мэдээлэл, танилцуулгыг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх.	Улирал бүр Сар бүрийн 5-ны дотор Тухай бүр Улирал бүр Тухай бүр Тухай бүр Тухай бүр	Сангийн яаманд хүргүүлсэн байна. Төслийн улирал тутмын зарцуулалтын тайланг бэлтгэж, үйл ажиллагааны зардлын дараа улирлын төсвийг, холбогдох төлөвлөгөө, баримтын хамт бэлтгэн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалтыг хийж гүйцэтгэнэ. Төслийн зарцуулалтын мэдээг сар бүрийн 5-ны дотор ЭЗХЯ, Сангийн яаманд хүргүүлсэн байна. Төслийн дотоодын НӨАТ-ын чөлөөлөлтийн тайланг цахим болон цаасаар бэлтгэн хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. НДШ, ХХОАТ-ын тайланг хуулийн хугацаанд харьяалагдах албанд шилжүүлж, тайлагнасан байна. Төсвийн гүйцэтгэл болон дансны мэдээллийг Шилэн дансны хуулийн дагуу хугацаанд нь тайлагнасан байна. Төсөлд холбогдох мэдээллийг нэгдсэн системд байнгын шинэчилж, баяжуулсан байна. Холбогдох мэдээллээр тухай бүр хангаж ажилласан байна.
17. Банкны данс, кассын тайлангуудыг гаргах, бүртгэх, нэхэмжлэх, гэрээг шалгах;	Сар бүр	Тайлангуудыг цаг хугацаанд нь гаргасан байна.

18. Ажил гүйлгээ болон бүх төлбөрийн баримт бичиг, нэхэмжлэх болон бусад санхүүгийн баримт бичгийг хадгалах;	Тухай бүр	Холбогдох баримт бичгийг хадгалсан байна.
19. Хөгжлийн түнш байгууллагуудын CPD болон LFIS порталуудад ажиллах, шаардлагын дагуу санхүүжилтийн хүсэлтийг цаг тухайд нь өгөх бусад тайлагналтын стандартуудыг мөрдөх;	Тухай бүр	Санхүүжилтийн хүсэлтүүдийг зохих журмын дагуу бэлтгэж, хүргүүлсэн байна.
20. МУ-ын засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем болох Одамисд холбогдох мэдээллүүдийг оруулах, тайлагнах;	Тухай бүр	Холбогдох мэдээллийг системд оруулсан байна.
21. Аудит хийхэд шаардагдах санхүүгийн тайлан, санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь бэлтгэх;	Тухай бүр	Холбогдох мэдээллийг бэлтгэж, хүргүүлсэн байна.
22. Аудитор эсвэл Хөгжлийн түншүүдийн илрүүлсэн зөрчлийн талаар яаралтай арилгах арга хэмжээ авч, тайлбарыг хүргүүлэх.	Тухай бүр	Зөрчлийг яаралтай арилгах арга хэмжээг авсан байна.
23. Төслийн захирал болон Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагчийн даалгасан бусад ажлыг гүйцэтгэх;	Тухай бүр	Заасан хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн байна.
24. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн эд хогшил, хөрөнгийн бүртгэлийг хийх;	Улирал бүр	Үндсэн хөрөнгийг зохих журмын дагуу бүртгэсэн байна.
25. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдах санхүүгийн программыг нэвтрүүлж, тайлан тооцоог санхүүгийн программын дагуу гаргах	Тухай бүр	Санхүүгийн программ ашиглан бүртгэл хөтөлж, тайлан тооцоо гаргасан байна.
Тайлбар: Ажил гүйцэтгэх хугацаа, хуваарийг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлно.		

В. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Дээд боловсролын бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй.	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, дүрэм журам, тайлангийн талаар мэдлэгтэй байх.
		Мэргэжил	- Нягтлан бодох бүртгэл /0411/ - Эдийн засаг /0311/	
		Туршлага	3-аас доошгүй жилийн Олон улсын байгууллагад санхүү, нягтлан бодох бүртгэл, хөрөнгийн удирдлагын чиглэлээр ажилласан туршлагатай.	
		Ур чадвар	Төслийн санхүүгийн талаар мэдлэгтэй байх.	Компьютерын хэрэглээний программ эзэмшсэн.
	1.2.Тусгай шаардлага	Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй.		

Г. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо: 2026.01.13

Дугаар: А/04

(тамга/ тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

(И.БАТХҮҮ)

2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр